



**“УЛААНБААТАР ТЕАТР” ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 06 сарын 30 өдөр

Дугаар Б/38

Улаанбаатар хот

**Албан хаагчдад үр дүнгийн урамшуулал
олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар театрын албан хаагчдын 2023 оны эхний хагас жилийн ажлын үр дүнг тооцож, театрын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, ажлын төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргээ хангалттай гүйцэтгэсэн уран бүтээлчдэд үр дүнгийн урамшуулал олгох албан хаагчдын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Тус тушаалын хавсралтаар баталсан албан хаагчдад олгох үр дүнгийн урамшуулалын хувьд ногдох мөнгөн хөрөнгийг зохих журмын дагуу, 7 дугаар сарын 10-ны дотор тооцон олгохыг Нягтлан бодогч (С.Эрдэнэцэцэг)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны ахлах мэргэжилтэн (Б.Түмэндэлгэр)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Ю.ГЭРЭЛБААТАР



D:/2023/secretary/dargiin tushaal /A4/

3140600107